



# ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ

---

2021 оны 03 болон 04 дэх долоо хоног

---

## ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ

2021 оны 01-р сарын 18-наас 01-р сарын 29-ний байдлаар

Ковид-19 дэлхий нийтээр хурдтай тархаж, цар тахлын түвшинд хүрээд буй өнөөгийн нөхцөлд глобал эдийн засаг, санхүүгийн зах зээлд томоохон өөрчлөлтүүд гарч байна. Эдгээр өөрчлөлтүүд болон эдийн засгийг тогтворжуулахад улс орнуудын авч хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээний талаар тухай бүр мэдээлж байх зорилгоор Монголбанкнаас долоо хоног тутам бэлтгэн хүргэж буй гадаад орчны тойм мэдээллийн 2021 оны 2 дахь дугаарыг хүргэж байна.

### 1 ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨ

- **Олон Улсын Валютын Сан “Дэлхийн эдийн засгийн төлөв” тайлангийн 2021 оны 1-р сарын шинэчилсэн дугаарт дэлхийн эдийн засаг 2021 онд 5.5 хувиар өсөх төсөөллийг танилцуулсан нь 2020 оны 10-р сарын төсөөллөөс 0.3 нэгж хувиар сайжирсан үзүүлэлт болов. Төсөөлөл сайжирсан нь вакцин бий болсон нөлөө болон томоохон эдийн засагтай улс орнуудын эдийн засгаа дэмжих багц хөтөлбөрүүдийн нөлөөгөөр тайлбарлагдаж байна. Түүнчлэн, дэлхийн эдийн засгийн өсөлт 2022 онд 4.2 хувь болж саарахаар байна. Эдийн засгийн үйл ажиллагаа 2020 оны 2-р хагаст хүлээлтээс өндөр байж, дэлхийн эдийн засаг 2020 онд урьдчилсан гүйцэтгэлээр 3.5 хувиар агшихаар тооцоолжээ. Энэ нь өмнөх 10-р сарын төсөөллөөс 0.9 нэгж хувиар бага агшилт боллоо. Эдийн засгийн сэргэлт, улс орнуудын авч хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээ, эмнэлэг, эмчилгээний чадвар, бүтцийн онцлог зэргээс шалтгаалан цар тахлын нөлөө улс орнуудад харилцан адилгүй байна. Цар тахлыг хяналтад оруулахын тулд улс орнуудын хамтын ажиллагаа чухал болохыг тайланд онцоллоо. Тухайлбал, дэлхийн улс орнуудад вакцины түгээлтийг хурдасгах, хүртээмжийг нэмэгдүүлэх, бага орлоготой орнууд ч вакциныг боломжийн үнээр хангах зорилготой ажиллаж буй **COVAX хөтөлбөрийн санхүүжилтийг нэмэгдүүлэх зэрэг хамтын ажиллагаа чухал** гэжээ.**
- **Олон Улсын Валютын Сангаас “Дэлхийн санхүүгийн тогтвортой байдлын тайлан”-г 1-р сарын 27-нд нийтэллээ.** Тус тайланд улс орнуудын төсөв, мөнгөний тэлэх бодлогын нөлөөгөөр санхүүгийн салбар хөрвөх чадварын эрсдэлээс сэргийлсэн ч ойрын хугацаанд төлбөрийн чадварын эрсдэл нүүрлэж болзошгүйг анхааруулжээ. Ялангуяа цар тахалд хүчтэй өртсөн салбаруудын зээл чанаргүй болох эрсдэл өндөр байна. Хүүний түвшин буурсан өнөөгийн нөхцөлд зээлийн чанар, ашигт ажиллагаатай холбоотой бэрхшээлүүд нь ойрын ирээдүйд банкуудын зээл олгох потенциал болон зээл олгох сонирхолд сөргөөр нөлөөлж болзошгүй. Цаашид эдийн засаг тогтвортой өсөлтөд хүртэл бодлогын

Ыдэмжлэгийг үргэлжлүүлэх нь чухал байгааг онцоллоо.

- **Олон Улсын Валютын Сан “Fiscal Monitor” тайлангийн 2021 оны 1-р сарын шинэчилсэн дугаарт хүний амьнас, амьжиргааг аврах, цар тахлын эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах асуудлуудад зарцуулсан**

дэлхийн санхүүгийн дэмжлэгийн нийт дүн 14 их наяд ам.долларт хүрээд байгааг онцлов. Улмаар төсвийн алдагдал тэлж, улсуудын өрийн хэмжээ асар ихээр нэмэгдэн, дэлхийн нийт өрийн хэмжээ 2020 оны эцэст ДНБ-ий 98 хувьд хүрсэн гэж тооцоолж байна.

**Хүснэгт 1. Дэлхийн томоохон санхүүгийн байгууллага, олон улсын агентуудын дэлхийн эдийн засгийн өсөлтийн суурь төсөөллүүд**

|   | Эх сурвалжууд    | Төсөөлөл хийсэн огноо | Дэлхийн эдийн засгийн өсөлт |             | БНХАУ-ын өсөлт | АНУ-ын өсөлт | Евро бүс өсөлт     | ОХУ-ын өсөлт          |
|---|------------------|-----------------------|-----------------------------|-------------|----------------|--------------|--------------------|-----------------------|
|   |                  |                       | 2020                        | 2021        |                |              |                    |                       |
| 1 | IMF              | 1/26/2021             | -3.5%                       | <b>5.5%</b> | 8.1%           | 5.1%         | 4.2%               | 3.0%                  |
| 2 | World bank       | 1/12/2021             | -4.3%                       | <b>4.0%</b> | 7.9%           | 3.5%         | 3.6%               | 2.6%                  |
| 3 | Roubini          | 1/25/2021             |                             | <b>5.6%</b> | 7.8%           | 4.4%         | 4.2%<br>(Eurozone) | 3.0%<br>(2020.12 cap) |
| 4 | Reuters          | 1/26/2021             | -3.9%                       | <b>5.3%</b> |                |              |                    |                       |
| 5 | Oxford Economics | 1/20/2021             | -3.9%                       | <b>5.0%</b> |                |              |                    |                       |
| 6 | United Nations   | 1/25/2021             | -4.3%                       | <b>4.7%</b> | 7.2%           | 3.4%         | 5.0%               | 3.0%                  |
| 7 | Fitch            | 12/7/2020             | -3.7%                       | <b>5.3%</b> | 8.0%           | 4.5%         | 4.7%<br>(Eurozone) | 3.0%                  |
| 8 | OECD             | 12/1/2020             | -4.2%                       | <b>4.2%</b> | 8.0%           | 3.2%         | 3.6%               | 2.8%                  |
|   | <b>Дундаж</b>    |                       | <b>-4.0%</b>                | <b>5.0%</b> | <b>7.8%</b>    | <b>4.0%</b>  | <b>4.2%</b>        | <b>2.9%</b>           |

Эх сурвалж: Төсөөлөл хийсэн байгууллагуудын цахим хуудсууд

- **Дэлхийн банкнаас дэлхийн эдийн засаг 2021 онд 4.0 хувиар өсөх төсөөллийг 1-р сарын 12-нд зарлалаа.** Цар тахлын тархалт эрчимжиж байгаа нь эдийн засгийн сэргэлтийг удаашруулж байгаа бол вакцинжуулалтын нөлөөгөөр хэрэглээ, гадаад худалдаа алгуур сэргэх төлөвтэй нь өсөлтийг тэтгэнэ гэж үзэж байна. Шинэ төсөөллөөр БНХАУ-ын эдийн засаг хурдтай сэргэж, 2021 онд 7.5 хувиар өсөх бол бусад эдийн засгууд цар тахлын нөлөөгөөр харьцангуй алгуур сэргэхээр байна. Монголын эдийн засаг 2020 онд 5.2 хувиар агших бол хэрэглээ, хөрөнгө оруулалт нэмэгдэн 2021 онд 4.3 хувиар

өсөх төсөөлөлтэй гэж Дэлхийн банкнаас төсөөлж байна.

- **Roubini Global Economics** байгууллагаас **дэлхийн эдийн засаг 2021 онд 5.6 хувиар өсөх** шинэчилсэн төсөөллийг 1-р сарын 25-нд зарлалаа. Энэ нь өмнөх төсөөллөөс бага зэрэг сайжирсан төсөөлөл юм. Суурь төсөөлөлд цаашид вакцины хамрах хүрээ нэмэгдсэнээр хөл хорио суларч, үйлчилгээний хэрэглээ оны 2-р хагаст сэргэх (ялангуяа хөгжингүй орнуудад)-ээр таамаглажээ. Төсөв, мөнгөний тэлэх бодлого 2022 оныг хүртэл үргэлжлэх нь эдийн засгийн сэргэлтийг дэмжинэ гэж үзэж байна. Харин гутранги хувилбарт вакцины хүртээмж



төсөөллөөс удаан байх, мутацид орсон вирусийн эсрэг вакцин үр нөлөөгүй байх эрсдэлтэй нь хэрэглээний сэргэлтийг хойшлуулах, эдийн засгийн бүтцийн өөрчлөлтийн улмаас урт хугацааны ажилгүйдэл бий болж, хөрөнгө оруулалт хумигдаж болзошгүй бөгөөд энэхүү хувилбараар дэлхийн эдийн засаг 2021 онд 2.5-4.5 хувиар өсөхөөр төсөөлжээ.

- Reuters агентлагаас Ази, Европ, Америкт 500 орчим эдийн засагчийн дунд явуулсан санал асуулгаар вирусын шинэ давалгааны нөлөөгөөр дэлхийн эдийн засаг цар тахлаас өмнөх түвшинд очтол дор хаяж 2 жил шаардагдахаар байна. **1-р сарын 7-26-ны хооронд явуулсан тус санал асуулгын үр дүнд дэлхийн эдийн засаг 2020 онд 3.9 хувиар агшиж, 2021 онд 5.3 хувийн өсөлттэй байна гэж үзжээ.** Нийт эдийн засагчдын 60 орчим хувь нь 2021 оны төсөөллөө өмнөхөөс бууруулжээ. Харин 2022 оны хувьд эдийн засгийн өсөлт өмнөх төсөөллөөс 0.5 нэгж хувиар нэмэгдэж 4 хувьд хүрэв. Санал асуулгаар эдийн засагчдын дийлэнх нь төсөөллийн таамаглалаа өмнөхөөс бууруулж эсвэл өөрчлөлгүй үлдээсэн нь вакцинууд шинэ, мутацид орсон вирусын эсрэг үр дүн багатай байх эрсдэлийг таамаглалдаа тусгасантай холбоотой байв.
- **НҮБ-ийн Эдийн засаг, нийгмийн харилцааны хэлтсээс “Дэлхийн эдийн засгийн төлөв 2021” тайланг 1-р сарын 25-нд нийтэллээ.** Уг тайланд **дэлхийн эдийн засаг 2020 онд 4.3 хувиар агших, 2021 онд 4.7 хувиар өсөхөөр төсөөлжээ.** Цар тахлаас үүдэлтэй хөл хорионы улмаас хөгжингүй орнуудын эдийн засаг 2020 онд 5.6 орчим хувиар агшиж, 2021 онд 4 хувийн өсөхөөр тооцоолсон байна. Хөгжиж буй орнуудын эдийн засаг харьцангуй бага

буюу 2020 онд 2.5 хувиар агшиж, 2021 онд 5.7 хувийн өсөлттэй байна гэж үзжээ. Хамгийн буурай хөгжилтэй орнуудын эдийн засаг 2020 онд 1.3 хувиар агшиж, 2021 онд 4.9 хувийн өсөхөөр байна. Латин Америк, Карибийн тэнгис, Өмнөд Азийн орнуудын эдийн засаг хамгийн огцом унасан бол Зүүн Азийн эдийн засаг бусад хөгжиж буй бүс нутгийн эдийн засагтай харьцуулахад сайн буюу 2020 онд 1 хувийн өсөлттэй, 2021 онд 6.4 хувиар өсөхөөр байна. G20-ийн орнуудын эдийн засаг 2020 онд 4.1 хувиар агших, үүнээс зөвхөн БНХАУ-ын эдийн засаг 2020 онд тэлэлттэй байна гэж тооцоолжээ.

– **Хөгжиж буй эдийн засагтай улс орнуудын 20 хувьд 2020 оны төсвийн алдагдал ДНБ-ий 10-аас дээш хувьтай тэнцэж байна.** Өсөлт удааширснаар төсвийн алдагдал улам тэлэхийн зэрэгцээ, дэлхийн нийт өрийн хэмжээ 2020 онд 9.9 орчим их наяд ам.доллараар өссөн гэх урьдчилсан тооцоог гаргажээ. Энэ нь Дэлхийн II дайнаас хойшхи хамгийн өндөр дүн болохоор байна. Хэдий төсвийн орлого буурч, алдагдал тэлж, өрийн хэмжээ нэмэгдээд байгаа ч засгийн газрууд зарлагаа хэт танахгүй байх нь чухал болохыг **НҮБ-ийн “Дэлхийн эдийн засгийн төлөв 2021”** тайланд онцолжээ. Учир нь төсвийн зарлагыг хэт танаснаар эдийн засгийн сэргэлт удаашрахын зэрэгцээ чанаргүй болох эрсдэлтэй юм.

– “Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн Байгууллага”-аас (OECD) хийсэн судалгаагаар цар тахлаас үүдэлтэй хөл хорионы улмаас OECD-д багтдаг орнуудын **ажилгүйдлийн түвшин 2020 оны 4-**



р сард **8.8 хувьд хүрсэн бол 11-р сард 6.9 хувь болж буурсан** байна.

– Цар тахлын хямралын улмаас **2020 онд дэлхийн ядуурлын түвшинд байгаа хүмүүсийн тоо 131 саяар нэмэгджээ**. 2030 он гэхэд 797 сая орчим хүн туйлын ядууралд автсан хэвээр байх тооцоог гаргаад байна.

- АНУ-ын эдийн засгийн шинжилгээний хороо (ВЕА)-ийн урьдчилсан тооцоогоор **АНУ-ын эдийн засаг 2020 оны 4-р улиралд жилийн 4 хувиар өсч, 2020 онд жилийн 3.5 хувиар агшлаа**. Эдийн засгийн 4-р улирлын өсөлтөд экспортын өсөлт (ихэвчлэн аж үйлдвэрлэлийн орц, материал), хувийн хэрэглээний өсөлт (голлон эрүүл мэндийн үйлчилгээ, хүнс, ундааны хэрэглээ), үндсэн хөрөнгийн хуримтлалын өсөлт, орон сууцны (ихэвчлэн нэг өрхийн орон сууцны) хөрөнгө оруулалт, эргэлтийн хөрөнгийн өсөлт зэрэг нөлөөллөө.
- **АНУ-ын Холбооны нөөцийн банк (ХНБ) 1-р сарын 26-27-нд хуралдаж, бодлогын хүүг 0-0.25 хувьд хэвээр үлдээх, сард 120 тэрбум ам.долларын бонд худалдан авалтын хөтөлбөрөө энэ түвшинд нь үргэлжлүүлэхээр шийдэв**. Түүнчлэн, ХНБ оны эхэнд нийтэлдэг “Урт хугацааны зорилт болон мөнгөний бодлогын стратегийн мэдэгдэл”-д 2020 оны 8-р сард баталсан урт хугацаанд инфляцыг дунджаар 2 хувийн түвшинд хадгалах стратегийг хэвээр үлдээв.
- **Европын төв банк 1-р сарын 21-ны өдрийн мөнгөний бодлогын зөвлөл (Удирдах зөвлөл)-ийн хурлаар хадгаламжийн хүүг хасах 0.5 хувьд хэвээр үлдээж, "Цар тахлын үед яаралтай тусламжийн арга хэмжээ авах хөтөлбөр (PEPP)"-ийн хүрээнд бонд худалдан авалтын дүнг 185 их наяд евро буюу хэвээр хадгалахаар**

**шийдэв**. Халдварын тоо нэмэгдсээр байгаа нь эдийн засгийн сэргэлтэд эрсдэл дагуулж байгааг Төв банк онцолж, эдийн засгийг дэмжих зорилгоор зээлийн өртгийг бага байлгаж, бонд худалдан авалтыг үргэлжлүүлж, шаардлагатай тохиолдолд нэмэлт санхүүжилтийн дэмжлэг үзүүлэхэд бэлэн байгаагаа зарлалаа. “Вакцин том амжилт бөгөөд эдийн засгийн сэргэлтэд эерэг хөшүүрэг болж байгаа ч Европын төв банк КОВИД-19-ийн хямрал бүрэн дуустал эдийн засгийг дэмжих багц хөтөлбөрүүдээ үргэлжлүүлнэ” гэж Европын төв банкны Ерөнхийлөгч К.Лагард мэдэгдэв.

- **Японы Төв банк 1-р сарын 20-ны мөнгөний бодлогын хурлаараа богино хугацаат бодлогын хүүг хасах 0.1 хувьд хэвээр хадгалж, 10 жилийн хугацаатай ЗГ-ын бондын өгөөжийг 0 орчим хувьд хадгалах зорилгоор Японы ЗГ-ын бондыг дээд хязгаар тогтоохгүйгээр шаардлагатай хэмжээгээр худалдан авахаа мэдэгдлээ**. ААН-ийн санхүүгийн дарамтыг бууруулах зорилгоор хөрөнгө худалдаж авах болон зээл олгох хөтөлбөрт томоохон өөрчлөлт оруулсангүй.

#### Эх сурвалж:

1. Oxford economics, [World economic prospects](#)
2. Fitch Rating, [Global economic outlook - December](#)
3. IMF, [Global Financial Stability Report](#)
4. MSN, [Global economy threatened by Covid-19 resurgence](#)
5. OECD, [Economic outlook](#)
6. World bank, [Global economic prospects](#)
7. BEA, [Gross Domestic Product, 4<sup>th</sup> Quarter and Year 2020 \(Advance Estimate\)](#)
8. The Federal Reserve, [Federal Reserve issues FOMC statement](#)
9. Reuters, [ECB stays put but warns about surge in infections](#)
10. IMF, [World economic outlook](#)
11. IMF, [Fiscal Monitor Update, January 2021](#)

- **Блүүмбергийн 2021 оны 1-р сард хийсэн судалгаагаар БНХАУ-ын эдийн засаг 2021 онд өмнөх төсөөллөөс 0.1 пунктээр сайжирч, жилийн 8.4 хувиар өсөхөөр төсөөлжээ.** Өсөлтөд дотоод эрэлт хүлээлтээс нэмэгдэх төлөв голлон нөлөөлж байна. Үүний зэрэгцээ оны 2-р хагаст улс орнуудад вакцинжуулалт амжилттай өрнөснөөр экспортын өсөлт хүлээлтээс ихээр, мэдэгдэхүйц нэмэгдэх төлөвтэй. Гэсэн хэдий ч БНХАУ-ын санхүүгийн секторт эрсдэл хуримтлагдаж буй нь энэ оны өсөлтийн төлөвт эрсдэл үүсгэж байна.
- **БНХАУ-ын Засгийн газраас Цагаан сарын баяртай холбоотой агаарын аяллыг хязгаарлах зорилгоор зорчигчдыг КОВИД-19-ын шинжилгээний сөрөг хариутай байхыг шаардаж байсан бол сүүлд авч хэрэгжүүлэх шийдвэр нь одоогийн байдлаар борлуулагдсан тасалбаруудыг бүгдийг нь цуцалж, дотоодын нислэгийн компаниудыг тийзийн үнээ торгуульгүйгээр буцаах эсвэл хугацааг хойшлуулах нөхцөл бүрдүүлэхийг үүрэг болгожээ.** Цагаан сарын нүүдлийн үе нь нислэгийн компаниудын хувьд хамгийн завгүй, өндөр ашигтай улирал юм. БНХАУ-ын дотоодын нислэгүүдийн тоо 2020 оны 12-р сард цар тахлын өмнөх түвшинд хүрээд байв. Харин энэхүү арга хэмжээний нөлөөгөөр зорчигчдын тоо 2019 оны цагаан сарын өмнөх түвшнээс 55 хувиар буураад байна.
- Дотоодын үйлдвэрлэл нэмэгдэж, экспорт өссөн, үйлдвэрлэгчдийн үнийн бага зэргийн дефляци болон өмнөх оны бага суурь үеийн нөлөө зэргээс шалтгаалан **БНХАУ-ын аж үйлдвэрлэлийн ашигт ажиллагаа 2020 оны 12-р сард өмнөх сараас нэмэгдэв.** Үүнд:
  - a) Аж үйлдвэрлэлийн ашиг 11-р сард өмнөх оны мөн үеэс 15.5 хувиар өссөн бол 12-р сард хүлээлтэд нийцтэйгээр 20.1 хувиар өссөн нь 2018 оны 6-р сараас хойшхи хоёр дахь өндөр өсөлт болов. Улмаар аж үйлдвэрлэлийн ашиг 2020 онд жилийн 4.1 хувиар өсөв.
  - b) Үйлдвэрлэлийн өсөлт 11-р сард өмнөх оны мөн үеэс 7 хувиар өссөн бол 12-р сард 7.3 хувиар өсөв.
  - c) Гадаад эрэлт өндөр буюу экспорт 12-р сард өмнөх оны мөн үеэс 18 хувиар нэмэгдсэн нь аж үйлдвэрлэлийн ашигт нөлөөлөв. Ирэх саруудад экспортын өсөлт хадгалагдах төлөвтэй.
  - d) Түүхий эдийн үнийн өсөлт мөн өсөлтөд эерэг нөлөө үзүүлээ. 2020 оны 12-р сард газрын тосны үнэ өмнөх сараас нэмэгдсэнээр үйлдвэрлэлийн орцын дефляци багасав. 2021 оны 1-р улиралд үйлдвэрлэлийн үнийн индекс дефляцаас инфляц уруу шилжих төлөвтэй.
  - e) Мөн үйлдвэрлэлийн ашиг 2019 оны 12-р сард 6.3 хувиар буурч байсан суурь үеийн нөлөө байгааг



Блүүмбергийн шинжээчид онцолж байна.

f) Харин, жижиглэн худалдаа төдийлөн нэмэгдээгүй нь өсөлтөд сөргөөр нөлөөлөв. БНХАУ-ын хойд хэсэгт хэрэгжүүлж буй цар тахлын эсрэг арга хэмжээнүүд чангарах төлөвтэй байгаа нь өрхийн хэрэглээ, аж үйлдвэрлэлийн ашигт ажиллагаанд сөргөөр нөлөөлж болзошгүй байна.

- **БНХАУ-ын албан ёсны боловсруулах үйлдвэрлэлийн PMI индекс** 12-р сард 51.9 байсан бол 2021 оны 1-р сард хүлээлтээс бага зэрэг өндөр 51.7-д хүрэх төлөвтэй. Харин экспортод суурилсан Caixin боловсруулах үйлдвэрлэлийн индекс 12-р сард 53 байсан бол 2021 оны 1-р сард хүлээлтээс багаар буурч 52.8 хүрэх төлөвтэй. Албан ёсны боловсруулах үйлдвэрлэлийн бус индекс 12-р сард 55.7 байсан бол 1-р сард хүлээлтээс багаар 54.7 тус тус хүрэхээр байна. Ийнхүү ҮҮИ хүлээлтэд нийцтэйгээр өсөхөд КОВИД-19-ийн тархалт

нэмэгдэн, хөл хориог хэсэгчлэн хэрэгжүүлж байгаа ч БНХАУ-ын худалдааны түнш орнуудын боловсруулах салбарын өсөлтүүд хадгалагдсан нь голлон нөлөөлөв. 2021 оны 1-р сард АНУ-ын Markit PMI индекс 59.1 буюу түүхэн өндөр түвшинд, Евро бүсийн PMI индекс 50-аас дээш хадгалагдаж тэлэлт үргэлжлэв. Мөн БНХАУ-ын экспортын өсөлтийг илэрхийлэх голлох индикатор болох Өмнөд Солонгосын экспорт оны эхний 20 хоногт өмнөх оны мөн үеэс 10.2 хувиар өсөөд байна. Харин Үйлдвэрлэлийн бус PMI индекс буурахад өвлийн саруудад ажиглагддаг барилгын салбарын бага идэвхжил, өмнөх жилүүдээс илүү хүйтэн өвөл болж, хэрэглээ сул байгаа нь голлон нөлөөллөө.

#### **Эх сурвалж:**

1. *China Airlines suffer as millions of trips cancelled: BNEF, Bloomberg*
2. *China Preview: PMIs to show consumption slipping on virus hit, Bloomberg*
3. *China React: Double digit industrial profits support PBOC Taper, Bloomberg*

**МОНГОЛ УЛСЫН ЭКСПОРТЫН ГОЛ ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНИЙН ӨӨРЧЛӨЛТ**

| Бодит гүйцэтгэл           |                               |          |        |         |              |       | Товч тайлбар  |
|---------------------------|-------------------------------|----------|--------|---------|--------------|-------|---|
|                           | Үнэ<br>(-1 day)<br>2021/01/27 | Өөрчлөлт |        |         |              | YoY   |   |
|                           |                               | daily    | weekly | monthly | year to date |       |   |
| <b>Зэс</b>                | 7821.2                        | 0.0%     | -2.4%  | 0.6%    | -0.3%        | 37.8% | Дэлхийн хэмжээнд КОВИД-19-ийн халдварын тохиолдол нэмэгдсээр байгаа ч улс орнуудад вакцинжуулалт эхэлсэн нь зах зээлд оролцогчдын итгэлд эерэгээр нөлөөлж үнэ хадгалагдахад нөлөөлж байна. Харин ам.доллар бага зэрэг чангарсан нөлөөгөөр ам.доллараар илэрхийлэгддэг металлын эрэлт бага зэрэг сулрав.           |
| <b>Төмрийн хүдэр</b>      | 161.3                         | 0.0%     | -1.4%  | 2.6%    | 5.5%         | 95.5% | БНХАУ энэ онд барилгын салбараа эрчимтэй дэмжих хүлээлттэй тул төмрийн хүдрийн эрэлт сайн байх төлөвтэй хэдий ч өвлийн саруудад идэвхжил буурсантай холбоотойгоор үнэ буурав.   |
| <b>Алт</b>                | 1843.9                        | -0.5%    | -1.8%  | -2.0%   | -5.5%        | 16.4% | Дэлхийн эдийн засгийн тодорхой бус байдал бүрэн буураагүй, хөгжингүй орнуудад мөнгөний тэлэх бодлогууд үргэлжилж байгаа тул аюулгүй хөрөнгө оруулалтад тооцогддог алтны эрэлт өндөр байна. Харин улс орнуудад вакцинжуулалт эхэлсэн мэдээ зах зээл дэх тодорхой бус байдлыг бууруулж алтны үнэ буурахад нөлөөлөв. |
| <b>Газрын тос (Брент)</b> | 55                            | -0.8%    | -1.3%  | 8.8%    | 8.3%         | -7.0% | КОВИД-19-ийн тархалт нэмэгдэж байгаа нь газрын тосны үнийг бууруулах чиглэлд нөлөөлж байна. Олон улсын эрчим хүчний байгууллагын тооцооллоор дэлхийн газрын тосны эрэлт 2021 оны дунд хүртэл төдийлөн нэмэгдэхээргүй байна.   |

**Зураг 1. Дэлхийн зах зээл дээрх алт, төмрийн хүдрийн спот үнэ**



**Зураг 2. Дэлхийн зах зээл дээрх зэс, газрын тосны үнэ**

